



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Орон тооны бус ёс зүйн албыг
шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30.1.15, 30.2, 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/811 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.1, 2.4, 2.5, 2.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын орон тооны бус ёс зүйн албыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Н.Нямхорлоо

Тэргүүн дэд дарга, хурандаа,

Гишүүд:

Ж.Төмөрмандах

Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

Ж.Алтанхуяг

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн сургалт, бэлэн байдал, гал унтраах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Э.Пүрэв-Очир

Захиргааны удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөх, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч,

Ж.Оюунчимэг

Захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн хэрэг хөтлөгч, энгийн,

Нарийн бичиг:

Ч.Батболд

Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад,

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2019 оны А/09 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулж бие бүрэлдэхүүний сахилга хариуцлагыг дээшлүүлж хяналт тавьж ажиллахыг ёс зүйн албаны дарга, хурандаа Н.Нямхорлоод үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ байгуулж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН